

**2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 07 дугаар сарын 31-ний “Даваа” гарагийн 12:00 цагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
2023-2024 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
1	Нийслэлийн Засаг даргын 2023 оны Нийслэлийн “2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/817 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, төлөвлөсөн ажлаа эрчимжүүлж ажиллах хүрээнд гарсан дүүргийн 2023-2024 оны өвөлжилтийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлуудын биелэлтийг холбогдох байгууллагууд 2023.07.28-ны өдрийн дотор ТХҮХ-т ирүүлэх.	ТХҮХ, Инженерийн хангамжийн байгууллагууд
2	Авто зам, замын байгууламж, нүхэн гарц, хайс хашлагийн цэвэрлэгээ үйлчилгээ, засвар арчлалтын ажлыг тогтмол хийж, аюулгүй байдлыг хангаж ажиллах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
3	Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах, авто замын шар тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, анхааруулга, санамж бүхий тэмдгүүдийг 09 дүгээр сарын 01-ний дотор байршуулж, урсгал засварыг дуусгах.	Боловсролын хэлтэс, ЕБС, СӨБ-ын байгууллагууд
4	Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ үйлчилгээ болон засвар шинэчлэлтийн ажлыг батлагдсан графикийн дагуу хийж гүйцэтгэн, үер усны аюулаас тогтмол урьдчилан сэргийлж ажиллах.	ОБХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
5	Үерийн аюулын улмаас учирсан хор уршигт дүн шинжилгээ хийх, эвдэрсэн авто зам, явган зам талбайг засварлах, зам дээр тогтсон усыг соруулах, сүвэгчлэх, цэвэрлэх, ариутгаж халдваргүйжүүлэх ажлуудыг эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ, Хороод, Дэд бүтэц, тохижилт, гэрэлтүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд
6	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнг танилцуулах.	ТХҮХ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
7	НИТХ-ын 2023 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг батлах тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай захирамж, журмын төсөл боловсруулах.	ТЗУХ, ХААТ, МЭТ
8	Гахайн аж ахуй эрхлэхтэй холбогдуулан тодорхой эзэнтэй, маллагаатай, хариуцлагатай байлгах талаар арга хэмжээ авах тухай захирамжийн төсөл боловсруулах.	ХААТ, МЭТ
9	Дүүргийн “Өндөрлөг”-рүү эрчим хүч татах талаар техникийн нөхцөл авах, дүүргийн онцлог давуу талыг харуулсан танилцуулга, мэдээлэл бүхий самбар байршуулах шаардлагатай тул загварыг гаргаж танилцуулах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
10	Дүүргүүдийн эрүүл мэндийн төвийн зоорийн давхарт үерийн ус орж байгаа асуудалд НЭМГ-аас цогц арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа тул бодит мэдээ мэдээллээ танилцуулж, холбогдох асуудлыг шийдвэрлүүлэх талаар уламжлах.	ЭМТ

11	Түүвэр цэвэрлэгээний ажлуудаа эрчимжүүлж, дуусгах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ОБХ, Хороод
12	Дүүргийн төв талбайн засварын ажлыг эхлүүлэх.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
13	“Хангай парк -1”, Илч-Орд ОНӨААТҮГ-ын хашаа нурах эрсдэл үүссэн тул холбогдох арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэн, аюулгүй байдлыг хангаж ажиллах	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж Илч-Орд ОНӨААТҮГ-ууд
14	Гэрэлтүүлгийн асалтыг 100 хувьд хүргэж, гэрэлтүүлгийг шилжүүлэх байршлуудын ажлыг энэ 7 хоногт дуусгах, усан оргилуурын өнгө үзэмжийг сайжруулах ажилд хяналт тавих.	ТХҮХ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
15	Дүүрэгт цаг уурын мэргэжилтэн (Цаг уурч) ажиллуулах талаарх боломж нөхцлийг судалж танилцуулах.	ТЗУХ
16	Дүүргийн 1 дүгээр хорооны орцны засварын ажилд тавих хяналтыг сайжруулж, хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх.	Холбогдох ажлын хэсгүүд
17	Баяр наадам зохион байгуулдаг талбайн газрыг дүүргийн мэдэлд авах, шаардлагатай тохиолдолд эзэмшлийг өөр газарт шилжүүлэх талаар холбогдох арга хэмжээг зохион байгуулах.	ГЗБА